



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/06

Бөхт

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн, 4.1.23 дахь, заалт 32 дугаар зүйлийн, 32.1.12, дахь заалт Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2 дугаар багийн нутагт орших Баруун хөх ам гэдэг газарт Малын гоц халдварт Хонины цэцэг өвчний шинж илэрсэн тул 2024 оны 01 дүгээр сарын 10ны өдрөөс эхлэн тодорхойгүй хугацаагаар хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан хориглох үйл ажиллагааг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Хязгаарлалтын дэглэмийн үед хяналтын цэгт ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4.Сэжигтэй бүс орчмын төв зам дагуу хөдөлгөөнт эргүүл хийх, ариутгал хийж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг (Х.Уугандорж), тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Э.Ёндонпэрэнлэй)-д тус тус даалгасугай.


5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, байнгын сэрэмжлүүлэг, мэдээ хүргэж ажиллахыг Онцгой комиссын шуурхай штаб (Багийн Засаг дарга нар)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ


Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10ны
өдрийн А/06 тоот захирамжийн 1 дүгээр хавсралт



ХЯЗГААРЛАЛТЫН ДЭГЛЭМИЙН ҮЕД МӨРДӨЖ АЖИЛЛАХ

1. Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан дараах үйл ажиллагааг хориглосугай.
2. Өвчний голомтын бүсийн малын хашаанд гадны хүн оруулахгүй байх.
3. Өвчний голомтоос малын гаралтай түүхий эд бэлтгэх, худалдах, ойр орчмын хот айлын малтай малаа нийлүүлэх
4. Өвчний голомтын бүсээр дайран өнгөрч байгаа техник хэрэгсэлд ариутгалд халдваргүйжүүлэлт хийлгэхгүй нэвтрэх
5. Өвчний голомт, сэжигтэй бүсээс хүн, мал амьтан, техник хэрэгслийг гадагш гаргах, зөвшөөрөгдсөн цэгээс бусад газраар хорио цээрийн бүсэд нэвтрэх.
6. Зөвшөөрөлгүйгээр бэлчээр нутаг ус сэлгэн нүүх, хорио цээрийн болон сэжигтэй бүсээс гадагш отор нүүдэл хийх.
7. Сэжигтэй бүс орчмын төв зам дагуу хөдөлгөөнт эргүүл хийх, ариутгал хийж
8. Сэжигтэй болон голомтын бүсийн айл өрхийг вакцинжуулалтад бүрэн хамруулах
9. Байнгын хяналтын цэгийг ажиллуулах.

Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10 ны
өдрийн А/06 тоот захирамжийн 2 дугаар хавсралт



ХЯНАЛТЫН ЦЭГИЙН ХУВААРЬ

№	Овог нэр	Албан тушаал	Хугацаа
1	Д.Шинэбаяр	Багийн Засаг дарга	2024-01-11
	Н.Сундуйжав	Хүүхдийн цэцэрлэгийн ажилтан	
2	М.Цэвэгдорж	Багийн Засаг дарга	2024-01-12
	М.Амарбаяр	ЕБС-ийн ажилтан	
3	Л.Мөнхбадрах	Засаг даргын орлогч	2024-01-13
	Т.Мөнхбат	Жолооч	
4	Х.Уугандорж	ХААТасгийн мэргэжилтэн	2024-01-14
	У.Наранбаатар	Хүүхдийн цэцэрлэгийн ажилтан	
4	О.Амгалантөр	Хууль-Эрхзүйн мэргэжилтэн	2024-01-15
	Т.Бибиш	ЕБС-ийн ажилтан	
5	Э.Сумъяа	Багийн Засаг дарга	2024-01-16
	Л.Ганбат	ЕБС-ийн ажилтан	
6	Б.Баянжаргал	Улсын бүртгэгч	2024-01-17
	Ч.Мөнхбаяр	ЕБС-ийн багш	
7	Э.Ёндонпэрэнлэй	Хэсгийн төлөөлөгч	2024-01-18
	Г.Цэрэннадмид	ЕБС-ийн ажилтан	

Хяналтын цэгт гүйцэтгэх чиг үүрэг

1. Хяналтын цэгт 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.
2. Голомтын болон сэжигтэй бүсийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллана.
3. Хяналтын цэгж ажиллаж буй талаарх мэдээллийг Шуурхай штабт 2 цаг тутам мэдээллэнэ.
4. Зайлшгүй шаардлагаар голомтын болон сэжигтэй бүсэд нэвтэрч буй тээврийн хэрэгсэл, хүнд ариутгал халдваргүйтлийг хийж, бүртгэлийг хөтөлнө.